

**Ерөнхий мэргэжлийн эмчийн мэргэжлээр эмчлэх зөвшөөрөл олгох шалгалтын
жишиг сорил**

Хувилбар -15

1. Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх) Энэ хэлбэрийн сорил нь А, В, С, D, E гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.
 2. Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)
 - 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (A.)
 - 1 ба, 3 дугаар хариултууд зөв бол (B.)
 - 2 ба 4 дугаар хариултууд зөв бол (C.)
 - Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)
 - Бүх хариулт зөв бол (E.)
 3. Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.)
 - Зөв, Зөв, Зөв (A.)
 - Зөв, Зөв, Буруу (B.)
 - Зөв, Буруу, Буруу (C.)
 - Буруу, Зөв, Буруу (D.)
 - Буруу, Буруу, Буруу (E.)
- /1./ Уушгины буглааны рентген шинжийг нэрлэнэ үү:
- A. Зах, ирмэг нь тодорхой дугуй сүүдэр
 - B. Агаар агуулсан нимгэн ханатай хөндий
 - C. Шингэний түвшинтэй хөндий
 - D. Их хэмжээний сүүдэр үүссэн фон дээр олон тооны хөндий гарсан
 - E. Зах, ирмэг нь тодорхой бус, нэг төрлийн бус дугуй сүүдэр
- /2./ Пневмотораксын үед илрэх нийтлэг шинжийг нэрлэнэ үү.
- A. Ханиалгана
 - B. Аюулхайд өвдөнө
 - C. Цээж өвдөх, амьсгаадах
 - D. Цустай цэрээр ханиах
 - E. Тогшилтоор хэнгэргэн дуутай байх
- /3./ Шүүдэст плевритын үед дараахаас бусад шинжүүд илэрнэ
- A. Эмгэгтэй хэсгийн дээр тогшилтын дуу дүлий болно
 - B. Амьсгал болон бронхофони суларна
 - C. Голтын эрхтэнүүд эмгэгтэй тал руу шилжиж байрлана
 - D. Зүүн талын шүүдэст плевритын үед Траубегийн зай багасна эсвэл алга болно
 - E. Дууны доргион суларна
- /4./ Сүрьеэгийн каверныг уушгины буглаанаас ялгах шинжийг тодорхойлно уу:
- A. Хөндий цацагдсан голомтуудын хамт
 - B. Гөлгөр ханатай, шингэний түвшинтэй хөндий
 - C. Цустай цэр гарна
 - D. Хордлогын шинж
 - E. Эритроцитын тунах хурд ихсэх
- /5./ Сүрьеэгийн эсрэг давтан вакцин хийхдээ ямар сорилыг хэрэглэдэг вэ?
- A. Туберкулинд антители үүссэнийг тодорхойлох
 - B. Пиркегийн сорил
 - C. Мантугийн сорил
 - D. ДНХ-д үзүүлэх полимеразын гинжин урвал
 - E. Кохын сорил
- /6./ Уушгины суурь хэсэгт тогшилтын дуу дүлий болох шалтгааныг нэрлэнэ үү:
1. Шүүдэст плеврит
 2. Гялтангийн наалдац
 3. Уушгины нэвчдэс

4. Уушгины коллапс
 5. Өрц дээр байрлах
- /7./ Уушгины архаг бөглөрөлт өвчний гол эрсдэлт хүчин зүйл бол:
1. Тамхины утаа
 2. Гэрийн доторх агаарын бохирдол
 3. Ажлын тоостой нөхцөл
 4. Сүрьеэ
 5. Өндөр нас
- /8./ 30-45 насны хүнд уушгины эмфизем үүсэх шалтгаан юу байж болох вэ?
1. Тамхи татах
 2. Агаарын бохирдол
 3. @1-антитрипсины дутагдал
 4. Үлээвэр хөгжим үлээх
 5. Гуурсан хоолой тэлэгдэх
- /9./ Транссудатын шалтгааныг сонгоно уу.
1. СКВ
 2. Нефроз хам шинж
 3. Лимфом
 4. Гипотиреоз
 5. Сүрьеэ
- /10./ Торх хэлбэрийн цээж үүсэх шалтгаан:
1. Уушгины сүрьеэ
 2. Уушгины эмфизем
 3. Цээжний булчингийн миастени
 4. Уушгины архаг бөглөрөлт өвчин
 5. Өвчүүний гаж хөгжил
- /11./ Бөөрний ямар өвчний үед Ходсоны шинж илрэх вэ?
- A. Архаг гломерулонефрит
 - B. Архаг пиелонефрит
 - C. Бөөрний амилоидоз
 - D. Бөөрний поликистоз
- /12./ Нефроз хам шинжийн үед бөөрний дутагдлын оношлогоонд аль нь чухал вэ?
- A. Түүдгэнцэрийн шүүлт
 - B. Сийвэн дэх креатинин
 - C. Сийвэн дэх холестерин
 - D. Сувганцарын эргэн шимэгдэлт
 - E. Протеинурийн түвшин
- /13./ Шээсний доод замын үрэвслийн үед шээс ялгаралтын өөрчлөлтийн аль нь илрэх вэ?
- A. Анури
 - B. Гематури
 - C. Странгури
 - D. Никтури
 - E. Олигури
- /14./ Нечипоренкогийн сорил ямар гарвал өөрчлөлттэй гэж үзэх вэ ?
- A. Бактериури
 - B. Лейкоцитури 2000 дээш
 - C. Лейкоцитури 2000 хүртэл
 - D. Лимфоцитури
 - E. Протейнури 1 гр/л
- /15./ Доорхи шинж тэмдэгээс нэгээс бусад нь амилоидозын үед гарна
- A. Диаррей
 - B. Дизури
 - C. Шээсний өөрчлөлт
 - D. Хаван
 - E. Ууц нуруугаар өвдөх

/16./ Дээрх эмүүдээс аль нь альдостероны антогонист вэ ?

1. Фуросемид
2. Маннит
3. Урегит
4. Верошпирон
5. Лазикс

/17./ Эрүүл хүний шээс сүрлэн шар өнгөтэй байх нь шээсээр ямар будагч бодисууд ялгардагтай холбоотой вэ?

1. Урохром
2. Урозеин
3. Уроэритин
4. Урат
5. Урон

/18./ Бөөрний судасны шалтгаант гипертензийг ямар аргаар оношлох вэ?

1. Радиоизотопийн шинжилгээ
2. Рентген шинжилгээ
3. Хэт авиан доплерографи
4. Хэт авиан шинжилгээ
5. Бөөрний эдийн шинжилгээ

/19./ Нефроз хам шинжийн үед дараах шинж тэмдгүүдээс аль нь илрэх вэ?

1. Хаван
2. Гипопротеинеми
3. Протеинури
4. Лейкоцитури
5. Гематури

/20./ Бөөрний эмгэгийн идэвхжлийг доорхи эмнэл зүйн шинж тэмдэгт үндэслэн тогтооно.

1. Нефроз хам шинж илрэх
2. Протеинури ихсэх
3. Гематури ихсэх
4. Артерийн даралт тогвортой ихсэх
5. Бөөрний түүдгэцэрийн шүүлтийн хурд огцом буурах

/21./ Зимницкийн сорилоор бөөрний үйл ажиллагааг үзэхэд эрүүл хүмүүст өдөр шөнийн шээс 4:1 харьцаатай байдаг. Шөнийн шээсний хэмжээ бага байдаг нь бөөрний сувганцрын эргэн шимэгдэлт нь шөнийн цагт ихэссэн байдагтай холбоотой.

/22./ Архаг гломерулонефритээр олон жил өвчилсөн өвчтөнд бөөрний тархилаг эдийн хэмжээ илүүтэйгээр багасаж чанд авиан шинжилгээнд хоёр бөөрний хэмжээ ижил бус жижгэрнэ.

/23./ Маастрихтийн III удирдамжийн II хувилбарын эмчилгээний схемыг сонгоно уу?

- A. Омепразол+кларитромицин+метронидазол
- B. Денол+омепразол+кларитромицин+метронидазол
- C. Цемитидин+кларитромицин+метронидазол
- D. Денол+ кларитромицин+метронидазол
- E. Омепразол+кларитромицин+тетрациклин

/24./ Улаан хоолойн горойлтын онцлог

- A. Залгинуут горойж тээглэнэ
- B. Хахаж цацах
- C. Зовхи унжих
- D. Дуу гунших
- E. Залгиаснаас хойш өвчүүний ард горойно

/25./ Нойр булчирхайн цочмог үрэвслийн үед аль иммунодепрессантыг хэрэглэх вэ?

- A. Делагил
- B. Имуран

- C. Циклофосфамид
- D. Левамизол
- E. 5 фторурацил

/26./ Элэгний хатууралтай өвчтөний порталь гипертензийн үеийн эмчилгээнд тохирох хослолыг сонгоно уу.

- A. биеийн хүчний ачааллыг хязгаарлах, давсны хэмжээг багасгах, салуретик
- B. салуретик ба b-блокатор
- C. салуретикийг верошпиронтой хавсрах, давсны хэрэглээг хязгаарлах, b-блокатор

/27./ Олон жилийн турш өвөрмөц бус шархлаат өвчнөөр өвчлөх үед ямар хүндрэл үүсэх вэ.

- A. Бүдүүн гэдэсний хордлогот тэлэлт
- B. Бүдүүн гэдэсний нарийсал
- C. Гэдэснээс цус алдах
- D. Аденокарцинома
- E. Дивертикулез

/28./ Суулгалтыг шалтгаанаар нь хэрхэн ангилах вэ?

- 1. вирусын, бактерийн, паразитын
- 2. салмонеллез, шигеллез, хламидийн шалтгаант
- 3. гиперосмоляр, гиперсекреторны, гипермоторны
- 4. халдварын ба халдварын бус
- 5. хүүхдийн, насанд хүрэгчдийн

/29./ Бүдүүн гэдэсний эхлэл хэсэгт аль нь хамааралгүй вэ?

- 1. Мухар гэдэс
- 2. Мухар олгой
- 3. Хөндлөн гэдэс
- 4. Махир гэдэс
- 5. Өгсөх гэдэс

/30./ Улаан хоолойн сөөргөө өвчинийг илтгэх гол шинжийг нэрлэнэ үү?

- 1. Улаан хоолойн рН 4,0-өөс багасах
- 2. Хүчиллэг болох нь хоногт 1 цагаас удаан илрэх
- 3. Сөөргөө нь 5 минутаас удаан үргэлжлэх
- 4. Горойх
- 5. Одинофаги илрэх

/31./ Хэвийн C хэсгийн цэсний шинж чанар

- 1. Тунгалаг цайвар, шаргал, шүлтлэг
- 2. Ганц нэг лейкоцит, хучуур эд байна
- 3. Ганц нэг болзолт бус нян байна
- 4. Алтлаг шар, тунгалаг
- 5. Зууралдамхай, өтгөн, ногоон хүрэн өнгөтэй

/32./ Ходоод, дээд гэдэсний шархлаа хэвлийн хөндий рүү цоороход эмнэлзүйн ямар шинжүүд илрэх вэ?

- 1. Аюулхай, хэвлийн баруун талд гэнэт маш хүчтэй өвдөж эхэлнэ, өвдсөн цага минутаа хэлнэ
- 2. Өвчтөн албадмал байдалтай, хагас суугаа, өвдгөө нугалан гэдэс рүүгээ татсан
- 3. Хэвтэр өөрчлөх, ханиах, амьсгалахад өвдөлт ихэснэ
- 4. Хэвлийн урд хана чангарсан, амьсгалд оролцохгүй
- 5. Өвчтөнд бөөлжих, хий, баас гарахгүй байх, хүйтэн хөлс цутгах, даралт буурах, бие их сулрах шинжүүд илэрнэ

/33./ Шүүдэст энтеропатийн үед биеэр жигд бус тархсан хаван, хэвлийд шингэн хурах, гидроторакс, анасарка гэх мэт шинж тэмдэгүүд илэрнэ. Эмчилгээнд уураг нөхөх шаардлагатай.

/34./ Мухар гэдсэнд хоолны агуулагдахуун дахин хооллох хүртэл хэсэг саатах бөгөөд ходоод гэдэсний шинэ рефлекс нарийн гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөнийг ихэсгэж химус цааш орно.

- /35./ Гипокортицизмын үеийн биохимийн шижилгээнд гарах өөрчлөлт
- A. Гипокалиеми
 - B. Гиперкальциеми
 - C. Гипохлореми
 - D. Гиперальбуминеми
 - E. Гипергликеми
- /36./ 75гр глюкозын уусмал уулгаад 2 цагийн дараах цусны глюкозын хэмжээ хэд байвал глюкозын сорилд өөрчлөлттэй гэж үзэх вэ?
- A. 6.0 ммоль/л
 - B. 7.0 ммоль/л
 - C. 6.8 ммоль/л
 - D. 7.8 ммоль/л
 - E. 11.1 ммоль/л
- /37./ Тархмал хордлогот бахуу үүсгэх шалтгааныг нэрлэнэ үү
- A. HLA-B8, HLA-DR3
 - B. ангина
 - C. халдвар
 - D. стресс
 - E. цэвэршилт
- /38./ Анхдагч гипотиреозыг дараах шинжилгээний аль нь батлах вэ?
- A. T3, T4 ↓, ТТГ ↓
 - B. T3, T4 ↓, ТТГ ↑, йод 131-ийн шингээлт буурах
 - C. T3, T4 ↓, ТТГ ↓, йод 131-ийн шингээлт буурах
 - D. T3, T4 ↓, ТТГ ↓, йод 131-ийн шингээлт ихсэх
 - E. T3, T4 ↑, ТТГ ↑, йод 131-ийн шингээлт ихсэх
- /39./ Гипокортицизмын үед илрэх эмнэлзүйн шинж
- A. Цусны даралт ихсэх
 - B. Эрэгтэй хэлбэрээр үсжинэ
 - C. Марийн шинж
 - D. Амьсгалын тоо олширно
 - E. Бэлгийн сулрал
- /40./ Хоёрдогч гипокортицизмын үед дааврын шинжилгээнд гарах өөрчлөлтийг хэлнэ үү
- 1. АКТГ ихэснэ
 - 2. Кортикол буурна
 - 3. 17 ОКС ихэснэ
 - 4. АКТГ буурна
 - 5. Кортизол ихэснэ
- /41./ Бодисын солилцооны хам шинжийн эмийн эмчилгээг нэрлэ
- 1. Орлистат
 - 2. Статин
 - 3. Сульфанилмочевин
 - 4. Бигуанид
 - 5. Кальцийн бэлдмэл
- /42./ Хоёрдогч гипокортицизмын үед эргэлдэх цусны хэмжээ ихэснэ. Учир нь хоёрдогч гипокортицизмын АКТГ их ялгардаг.
- /43./ Эмнэл зүйн ямар хэлбэрийн перикардит нь зөвхөн архаг явцтай байдаг вэ?
- A. Хуурай
 - B. Наалдаст
 - C. Шүүдэст
 - D. Шүүдэст ба наалдаст
 - E. Хуурай ба наалдаст

- /44./ Цусны сийвэнд АСЛО эерэг гарвал юуны тухай бодох вэ?
- Хэрлэг өвчтэй байна
 - Архаг тонзиллит өвчтэй байна
 - Стрептококкийн халдвар авч эсрэг биет үүссэн байна
 - Стрептококкийн эсрэг төрөгч илэрсэн байна
- /45./ Зүрхний шигдээсийн эхний 24 цагт булчин тариа хийхийг зөвлөдөггүй. Яагаад?
- Тарианы үйлчилгээ удаан эхэлдэг
 - Эмчилгээний үр дүн хангалтгүй
 - Сийвэнд ферментийн идэвхжлийг зөв тодорхойлоход бэрхшээл учруулдаг
 - Хүндрэл өгдөг
 - Судсанд хийх нь илүү үр дүнтэй
- /46./ Нитроглицерины гол гаж нөлөөг заана уу
- Бөөлжис цутгах
 - Суулгах
 - Ханиалгах
 - Толгой өвдөх
 - Хоолонд дүргүй болох
- /47./ Шигдээсийн ямар хэлбэрийн үед бүлэн уусгах эмчилгээ заалттай вэ?
- Субэндокардын шигдээс
 - Субэпикардын шигдээс
 - Хүндрэлттэй шигдээс
 - Дахисан шигдээс
 - Давтан шигдээс
- /48./ Үндэсний эмнэл зүйн удирдамжид заасны дагуу зүрхний шигдээсийн үеийн бүлэн уусгах эмчилгээний үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгоно уу?
- Бүлэн уусгах эмчилгээний дараа 60 минутанд өргөгдсөн ST сегмент >50%-иар буух
 - Цээжний өвдөлт намдах
 - КФК-МВ ферментийн хэмжээ ихсэх
 - Бүлэн уусгах эмчилгээний дараа 90 минутанд өргөгдсөн ST сегмент >40%-иар буух
 - Титэм судасны зурагны эерэг өөрчлөлт
- /49./ Митрал судасны хавхлагын нарийслын үед гемодинамикийн ямар өөрчлөлт гарах вэ?
- Митрал хавхлагаар дамжих цусны гүйдлийн хурд ихсэх
 - Цусны гүйдлийн чиглэл өөрчлөгдөх
 - Зүрхний даралтны ачаалал нэмэгдэх
 - Цусны гүйдэлд саад учрах
 - Зүрхний эзлэхүүний ачаалал нэмэгдэх
- /50./ Зүрхний архаг дутагдлын эмчилгээнд хамааралтай зөв хариултыг сонгоно уу?
- Хоолны дэглэм барих, нэг дор их хэмжээгээр өгөхөөс зайлсхийх
 - Фуросемидыг шөнийн цагт өгөх нь илүү үр дүнтэй
 - Хэвтрийн дэглэм сахих
 - Нитратын бэлдмэлийг өдөрт 3 удаа өгөх
 - Фуросемидийг судсаар тарихад үр дүн нь уухаар хэрэглэснээс ялгаагүй
- /51./ Зүрх зогсоход хамааралтай зөв хариултыг сонгоно уу?
- Ховдлын фибрилляцийн хувь тавилан асистолийг бодвол илүү байна
 - Зүрхний бүтэн хориг нь зүрх зогсох гол шалтгааны нэг
 - Эрт дифибрилляци хийх нь амлуулах чухал арга хэмжээ мөн
 - Тосгуурын фибрилляци нь зүрх зогсохын нэг шалтгаан
 - Зүрх зогсоход амьсгал үргэлж байхгүй байна
- /52./ Миокардитыг эмнэл зүйгээр оношлоход түвэгтэй гэж үздэг, яагаад?
- Ховор тохиолддог
 - Өвөрмөц эмнэл зүйн шинж тэмдэг байхгүй
 - Олон хэлбэртэй
 - Шинж тэмдэггүй буюу далд явцтай байдаг
 - Бусад өвчнөөс ялган оношлох хэцүү

- /53./ Зүрхний дутагдалтай хүмүүс цээж толгойгоо өндөрлөн, хөлөө унжуулсан, албадмал байрлалд ордог. Энэ байрлал нь бага эргэлтийн зогсонгишлыг багасгаж өрцний хөдөлгөөнийг хөнгөвчилдөг тул амьсгаадалт багасдаг.
- /54./ Эритремитэй өвчтөнд цитостатик эмчилгээ хийх заалт аль нь вэ?
- A. Эритроцит $6.5 \times 10^{12}/л$ – ээс дээш
 - B. Тромбоцитын тоо $1000 \times 10^9/л$
 - C. Базофиль 3% - иас дээш
 - D. Шээсний хүчлийн диатез бий болох
 - E. Ходоодны хурц улайлт
- /55./ Төмөр дутагдлын цус багадалтын үеийг сонгоно уу?
- A. Төмөр дутагдлын цус багадалтын үеийн эмнэлзүй, лабораторын шинж илрэх үе
 - B. Сийвэнгийн Fe багасаж, гемоглобин хэвийн байх
 - C. Сийвэнгийн ферритин багасаж, Fe, гемоглобин хэвийн байх
 - D. Сийвэнгийн ферритин багасаж, төмөр ихсэх
 - E. Сийвэнгийн төмөр ихсэж, ферритин ихсэх
- /56./ Эмч гемофили А-тай өвчтнийг үзээд VIII хүчин зүйлд ингибитор үүссэн байж болох юм гэж үзжээ. Ингибитор үүссэнийг харуулах шинж юу вэ?
- A. Гемартроз
 - B. Хэвлийн арын өөхөн эслэг зайд цус хурах
 - C. Гемоторакс
 - D. Десмопрессиныг хэрэглэхэд үр дүнгүй хамрын цус алдалт
 - E. VIII хүчин зүйлийн концентратыг ердийн эмчилгээний тунгаар хэрэглэхэд үр дүн өгөхгүй цус алдалт илрэх
- /57./ Архаг лимфолейкозын үед миелограммын шинжилгээнд ямар өөрчлөлт гарах вэ ?
- A. Мегалобластын цус төлжилт
 - B. Бласт 30%-иас их байх
 - C. Ясны чөмөгт үсэрхийлсэн саркомын эсүүд харагдах
 - D. Ходжкиний эсүүд илрэх
 - E. Лимфоцит 30%-иас их болох
- /58./ Улаан эсийн задрал эрчимтэй явагдаж байгааг илтгэх шинжилгээний үзүүлэлтүүдийг нэрлэнэ үү.
- A. Улаан эсийн өнгө илтгэгч буурах
 - B. Сийвэнд билирубины хэмжээ ихсэх
 - C. Шээсний өнгө өөрчлөгдөх
 - D. Арьс, шарлах, загатнах
 - E. Захын цусанд ретикулоцитын тоо эрс ихсэх
- /59./ Гемофили өвчний эмнэлзүйн шинжүүдийг нэрлэнэ үү?
1. Арьсан доорх өөхөн эдэд булчинд цус хурах
 2. Үенд цус хурах
 3. Гэмтлийн дараа хэсэг хугацаа өнгөрөөд цус гоожиж эхлэх
 4. Гэмтлийн дараа шууд цус гоожиж эхлэх
 5. Салстын цус алдалтууд хавсрах
- /60./ Парапротейнемийн хэлбэрүүдийг нэрлэнэ үү?
1. Түгмэл миелома
 2. Вальденстромын макроглобулинеми
 3. Анхдагч амилоидоз
 4. Моноклоны гаммапати
 5. Хүнд гинжний өвчин
- /61./ Жирэмслэхээс хамгаалах 1-шатлалтай дааврын эмийн үйлчлэх механизм нь:
- A. Умайн салстын хөвсийлтийг саатуулна
 - B. Өндгөвчийн ажиллагааг бууруулна
 - C. Өнчин тархинд гонадотропин үүсч ялгарахыг дарангуйлна
 - D. Гипоталамусын релизинг шүүрлийн хэмнэлийг алдагдуулна
 - E. Өндгөвчийн ажиллагааг идэвхжүүлнэ

/62./ Өвчтөн Н. 23 настай. Анхны жирэмслэлтээ хууль бусаар үр хөндүүлж халдвар хордлогын дайрлагын III зэрэгтэй хүлээн авахад орж ирлээ. Ямар арга хэмжээ авах вэ?

- A. Маш яаралтай мэс засалд оруулна
- B. Өргөн хүрээтэй антибиотик эмчилгээг хэрэглэнэ
- C. Эрчимт эмчилгээний тасагт хэвтүүлж шокоос гаргах эмчилгээ хийж дараа нь мэс засалд оруулна
- D. Үүсгэгчийг тодруулах шинжилгээ хийж хүлээх тактик баримтлана
- E. Эмчилгээг ерийн тактикаар хийнэ

/63./ Ихэс түрүүлэлтийн үндсэн шинж тэмдэг юугаар илрэх вэ?

- A. Өвдөх
- B. Цус алдах
- C. Ургийн ус эрт гарах
- D. Ургийн зүрхний цохилт хурдсах
- E. Хавагнах

/64./ “Заг хүйтэн байж болзошгүй” үед эмэгтэйд өрхийн эмч ямар тусламж үзүүлэх вэ?

- 1. Тохирох антибиотикийг эмэгтэйд уулгана
- 2. Тохирох антибиотикийг хавьтагчид уулгана
- 3. Бэлгэвчийг зөв, байнга хэрэглэх талаар зөвлөгөө өгнө.
- 4. Дахин бэлгийн хавьталд орохгүй байхыг зөвлөнө
- 5. Эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ.

/65./ Жирэмсний явцад ямар эмгэг илэрвэл жирэмсэн эмэгтэйд өрхийн эмч дараах шатны эмнэлэгрүү шилжүүлэх вэ?

- 1. Жирэмсэнтэй хавсарсан эмгэгтэй
- 2. Олон урагт жирэмсэн
- 3. Ураг хөндлөн эсвэл буруу байрлалтай
- 4. Үтрээгээр цус гарч байгаа.
- 5. Төрсний дараа үрийн хоолой боолгох хүсэлтэй.

/66./ Жирэмсний хяналтын ач холбогдол нь

1. Хүндрэлийг эрт илрүүлж, жирэмслэлт төрөлтийн асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэх (өрхийн эмч),

- 2. Жирэмсэн эмэгтэй бүрийг фолийн хүчлээр эмчлэх
- 3. Артерийн даралт хэмжих, шээсэнд уураг тодорхойлох
- 4. Жирэмсэн эхийг чанар сайтай хоолоор хооллох нөхцөлийг бүрдүүлэх
- 5. Жирэмсэн эхчүүдийг төрөхөөс нь 7-14 хоногийн өмнө амруулах нөхцөлийг бүрдүүлэх

/67./ Улаан хоолойн нүхээр үүссэн өрцний хүндрээгүй гулсамтгай ивэрхийн үед мэс заслын эмчилгээг аль хувиар хийхийг заана уу?

- A. Өвчтөнүүдийн 10%-иасбага хувьд
- B. Өвчтөнүүдийн 20-40%-д
- C. Өвчтөнүүдийн 41-60%-д
- D. Өвчтөнүүдийн 61-80%-д
- E. 81-ээс их хувьд

/68./ Элэгний хатууралын үед улаан хоолой болон түүний амсрын хураагуур судас өргөссөний улмаас цус алдаж нас барах гол шалтгаануудыг заана уу.

- A. Цус алдсанаас шоконд орох
- B. Элэг бөөрний дутмагшил
- C. Цус алдалтын дараах цус багадалт
- D. Элэг хатууралтаас үүсэх хямралууд
- E. Элэгний даамжирсан дутагдал

/69./ Цээжний ханын дотор хальсны үрэвслийн 3 үндсэн онцлог чанарыг нэрлэ.

- A. Хориглох үйл + бичил биетэний өсөлтийг дарах чадвар + сорох өндөр чадвар
- B. Шүүдэс ялгаруулах чадвар + бичил биетэний өсөлтийг дарах чадвар + уушгаа хамгаалах чадвар
- C. Хориглох үйл + шүүдэс ялгаруулах чадвар + бичил биетэний өсөлтийг дарах чадвар
- D. Шүүдэс ялгаруулах чадвар + сорох өндөр чадвар + төлжих чадвар

Е. Бичил биетэний өсөлтийг дарах чадвар + төлжих чадвар + өвчнөөс уушгаа хамгаалах чадвар

/70./ Амилуулах амьсгалуулалт зөв хийж байгааг илтгэх үзүүлэлтийг нэрлэнэ үү?

- А. Өвчтөний хацар томбойх
- В. Өвчтөний аюулхай орчим цүрдийх
- С. Амьсгалуултын үед өвчтөний хамраар агаар урсаж гарах
- Д. Цээж тэлж, өвчүү өргөгдөх
- Е. Хавирга завсрын булчин хонхойж сорогдох

/71./ Зүрхний гаралтай цээжээр өвдөх эмнэлзүйн онцлогуудыг тэмдэглэнэ үү?

- 1. Цээжний өвдөх + амьсгал давчдах
- 2. Цээжний өвдөх + дотор муухайрч, бөөлжих
- 3. Цээжээр өвдөх+ толгой эргэх, муужрах
- 4. Цээжээр өвдөх + чацга алдах
- 5. Цээжээр өвдөх + хөлрөнө, арьс хөхрөнө, хөрнө

/72./ Хорт хавдартай амьдралын төгсгөлийн шатанд буй өвчтөн сэтгэлзүйн хямарлын хэдэн шатыг туулдаг вэ?

- А. Түгших, гутрах 2 шат
- В. Шоконд орох, бухимдах, дасан зохицолт хямрах, тавилангаа хүлээн зөвшөөрөх гэсэн 4 шат
- С. Бухимдах, түгших, гутрах 3 шат
- Д. Өвчнөө үгүйсгэж, оношоо бататгахыг оролдох, өөр эмч домч хайх бухимдлын шат

/73./ Ямар эмийн эмчилгээ өвчтөнд суулгалт үүсгэдэг вэ?

- 1. Туулга хэтрүүлэх
- 2. Антибиотик хэтрүүлэх
- 3. Метилналтрексон
- 4. Морфин
- 5. Кодеин

/74./ Баруун гар, мөр, цээжний баруун хагаст өвдөлт, t° мэдрэхүй арилсан. Мэдрэхүй алдагдсан хэвшинж:

- А. Ёзоорын хэвшинж
- В. дисталь хэвшинж
- С. Сегментын хэвшинж
- Д. Дамжих хэвшинж
- Е. Мононеврит хэвшинж

/75./ Хөдөлгөөний нейрон сонгомлоор гэмтдэг эмгэг

- 1. Полиомиелит
- 2. Полиневрит
- 3. Хажуугийн хатингиралт хатуурал
- 4. Нүүрний саа
- 5. Нугасны хавдар

/76./ Уушигны хоёрдогч сүрьеэгээс элбэг тохиолдох хэлбэрийг нэрлэнэ үү?

- А. Уушигны голомтот сүрьеэ
- В. Уушигны нэвчдэст сүрьеэ
- С. Уушигны туберкулема
- Д. Уушигны хөндийт сүрьеэ
- Е. Сорвит хөндийт сүрьеэ

/77./ Архаг архичин сүрьеэтэй тохиолдлын эмчилгээнд анхаарах зүйлсийг тоочно уу?

- А. Эмийг өдөр бүр харж уулгах
- В. Элэгний үйл ажиллагааг шинжилгээгээр хянах
- С. Эмнэлэгт хэвтүүлж эмчлэх
- Д. В" төрлийн витамин уулгах
- Е. Дээрхи бүгд

/78./ БЦЖ вакцинаар үүсгэгдсэн дархлалтай хүүхдэд илрэх туберкулины сорилын хариу урвалын онцлогийг тоочно уу?

- 1. Сорилд үүссэн гүвдрүүний хэмжээ жил бүр ихэснэ

2. Сорилд үүссэн гүвдрүүний хэмжээ жил бүр буурна
3. Хэт эерэг урвалтай буюу 10 мм-ээс дээш хэмжээтэй гүвдрүү үүснэ
4. Эерэг урвалтай буюу 10 мм-ээс доош хэмжээтэй гүвдрүү үүснэ
5. Улайлт гүвдрүүнээс том хэмжээтэй байна

/79./ БЦЖ вакцин нь хүүхдийг ямар хэлбэрийн сүрьеэгээр өвчлөхөөс найдвартай хамгаалах вэ ?

1. Уушигны бус эрхтэний сүрьеэ
2. Хурц тархмал сүрьеэ
3. Уушигны сүрьеэ
4. Сүрьеэгийн менингит
5. Анхдагч сүрьеэ

/80./ Халдварт мононцуклеозын үед гарах тууралт

- A. Жижиг гүвдрүүт
- B. Розеол
- C. Цэгчилсэн цусархаг
- D. Том гүвдрүүт
- E. Дээрх тууралтын элементүүд бүгд зөв

/81./ Галзуугийн вирус хүний биед хаана их хэмжээгээр хуримтлагдах вэ?

- A. Уураг тархинд
- B. Нугасанд
- C. Шүлсэнд
- D. Гэдсэнд
- E. Цусанд

/82./ Цусан суулга өвчин нэг хүртлэх насны хүүхдэд ямар онцлогтой илэрдэг вэ?

1. Өтгөн ус ихтэй, усгүйжилтэнд амархан орно
2. Өтгөн салс ихтэй
3. Бүдүүн гэдэсний үрэвслийн шинж бүдэг илэрсэн
4. Дисбактериоз болох нь амархан
5. Бөгсний амсар онгойно

/83./ Урвах тахал өвчний баасны шинж чанарыг тэмдэглэ.

1. Усархаг
2. Хэмжээ их
3. Үнэргүй
4. Цусны судалтай
5. Хоолны үлдэцтэй

/84./ Эрүүл нүдний жинхэнэ даралтын хэмжээ хэд байдаг вэ?

- A. 1-7 мм.муб
- B. 8-21 мм.муб
- C. 22-31 мм.муб
- D. 32-41 мм.муб
- E. 42-51 мм.муб

/85./ Нүдний аяганы өвчний үндсэн шинж тэмдэгийг нэрлэнэ үү.

1. Төв хараа муудах
2. Экзофтальм
3. Өнгө таних чадвар буурах
4. Энофтальм
5. Нүдний дотоод даралт ихсэх

/86./ Харааны мэдрүүлийн хөхлөгийн чанарын үнэлгээний үзүүлэлтийг нэрлэнэ үү

1. Нейроретиналь хүрээний хэлбэр
2. Нейроретиналь хүрээний өргөн
3. Экскавацийн байдал
4. ХМХ-ийн хэмжээ
5. Мэдрэлийн ширхэгийн давхаргын зузаан

/87./ Дунд чихний цочмог үрэвсэл үүсэх хамгийн түгээмэд зам юу вэ?

- A. Тимпаногенный

- B. Тубогенный
- C. Контактный
- D. Агаар дуслын
- E. Хавьтлын

/88./ Доорхи үйл ажиллагаануудын аль нь залгиурт хамаарагдах вэ?

- 1. Амьсгал-хоол дамжуулах
- 2. Хамгаалах
- 3. Дууг цуурайтуулах
- 4. Хурхирах
- 5. Хахах

/89./ Төвөнхийн гаднах арьсан хэсэг нимгэн (2мм), уян, хөдөлгөөнтэй боловч өөхөн давхарга зузаан (1), иймээс төвөнх хялбархан гэмтэхгүй (2).

/90./ 74 настай өвгөн шөнө босч шээдэг болсон тул нойр алдаад байна гэсэн зовиуртай өрхийн эмчид хандав. Түүний шээсний урсгал сул, бага багаар дүлж шээж байгаа, шээсэн хэрнээ давсганд шээс үлдэх мэт шинж илэрдэг ба заримдаа тэвчихэд хэцүү болдог гэж өгүүлсэн байв. Тэр ямар эмгэгтэй байх магадлалтай вэ?

- A. Чихрийн шижин
- B. Түрүү булчирхай томрох хам шинж
- C. Чихрийн бус шижин
- D. Зүрхний хаван шөнө бууснаас шээс элбэгшсэн байж болзошгүй
- E. Цистит

/91./ Настанд эрүүл урт удаан наслах талаар өрхийн эмч ямар зөвлөгөө өгөх ёстой вэ ?

1. Тэтгэвэрт гарсандаа сэтгэл ханамжтай, тайван байх, хийсэн, бүтээснээрээ бахархаж, өөртөө итгэлтэй байх.

2. 3 цагаан хорыг (чихэр, давс, өөх) хоол хүнснээс хязгаарлах, аминдэм, эрдсээр баялаг жимс, ногоо, сүү, цагаан идээ сайн идэх ба лаазалсан, шуузгалсан, даршилсан хүнс хэрэглэхгүй байхыг хичээх.

3. Биеийн тамирын дасгалыг тогтмол хийдэг байх, цэвэр агаарт явган алхадаг байх

4. Архи, тамхинаас хол байх

5. Амьдралдаа зорилготой, сэтгэл ханамжтай байх ба тогтмол сурч, нийгмийн идэвхитэй байх.

/92./ Настангийн үйл ажиллагааны чадварыг үнэлэхэд Карновскийн индекс 70 оноо бол юу гэж үнэлэх вэ?

A. Хэвийн үйл ажиллагаа явуулах чадвартай, өвчний ганц нэг шинж илэрсэн.

B. Хэвийн үйл ажиллагаа явуулах чадвартай боловч өвчний зарим шинжүүд илэрсэн.

C. Өөрийгөө арчлах чадвартай боловч хэвийн үйл ажиллагаа явуулах чадваргүй

D. Өөрийгөө арчлах чадвар маш муу тул тусгай асаргаа шаарддаг

E. Үхлүүд, өвчин маш хурдан даамжирч байгаа

/93./ Гериатрикс гэж юуг судалдаг шинжлэх ухаан бэ?

1. Настанд тохиолдох өвчин судлал

2. Нас дагаж биед гарах өөрчлөлт

3. Настанд тохиолдох өвчнөөс сэргийлэх, эмчлэх аргууд

4. Насжилттай холбоотой биологийн асуудлууд

5. Насжилттай холбоотой сэтгэц-нийгмийн асуудлууд

/94./ Хэрх төст үений үрэвслийн эмнэлзүйд илрэхгүй шинжийг нэрлэнэ үү.

A. Шегрений хам шинж

B. Бугуйн сувагны хам шинж

C. Богтосруу ханарах

D. Хунгийн хүзүү

E. Хулсан нуруу

/95./ Хэрх өвчний лаборатори шинжилгээнд гарахгүй өөрчлөлтийг нэрлэнэ үү.

1. Цагаан эс ихсэх

2. Альфа 2 глобулин ихсэх

3. АСЛО ихсэх
4. Гамма глобулин ихсэх
5. Ц урвалжит уураг ихсэх

/96./ Ревматоид артритын эмчилгээнд хэрэглэх DMARDS эмийг тодорхойлно уу:

1. Диклоденк
2. Сульфасалазин
3. Натрий салицилат
4. Метотрексат
5. Идеос

/97./ Эрхтэн тогтолцооны чонон хөрвөсийн оношлогооны шалгуурт аль нийцэх вэ:

1. Аманд шархлаа гарах
2. ANA илрэх
3. Уушгийг гэмтээх
4. Anti-phospholipid antibody
5. Үений үрэвсэл

/98./ CRP ямар эмгэгийн үед илэрч болох вэ:

1. Элэгний С вирусний гепатит
2. Эрхтэн тогтолцооны чонон хөрвөс
3. Ревматоид артрит
4. Эрхтэн тогтолцооны хатуурал
5. Ревматический артрит

/99./ Яс үений үрэвслийн (Osteoarthritis) эмнэлзүйг заана уу.

1. Үений өвдөлт
2. Үений хөдөлгөөн алдагдах
3. Шажигналт
4. Үений хөдөлгөөний далайц буурах
5. Үений шингэн багасах

/100./ Тулай өвчний үед үений шингэний шинжилгээнд кальцигидрофосфат тодорхойлогддог бол хуурамч тулайн үед үений шингэний шинжилгээнд уратын давс тодорхойлогддог.

Сорилын зөв хариулт

1-С, 2-С, 3-С, 4-А, 5-С, 6-Е, 7-А, 8-В, 9-С, 10-С, 11-В, 12-В, 13-С, 14-В, 15-В, 16-Д, 17-А, 18-В, 19-А, 20-Е, 21-А, 22-Д, 23-В, 24-Е, 25-Е, 26-С, 27-С, 28-Д, 29-С, 30-А, 31-Д, 32-Е, 33-А, 34-А, 35-С, 36-Д, 37-А, 38-В, 39-Е, 40-С, 41-С, 42-Д, 43-Д, 44-С, 45-С, 46-Д, 47-В, 48-А, 49-В, 50-В, 51-А, 52-С, 53-А, 54-В, 55-А, 56-Е, 57-Е, 58-Е, 59-А, 60-Е, 61-С, 62-С, 63-В, 64-А, 65-Е, 66-Е, 67-В, 68-В, 69-Д, 70-Д, 71-Е, 72-В, 73-А, 74-С, 75-В, 76-В, 77-Е, 78-Д, 79-С, 80-Е, 81-С, 82-Е, 83-А, 84-В, 85-С, 86-В, 87-В, 88-А, 89-Е, 90-В, 91-Е, 92-С, 93-В, 94-Е, 95-В, 96-С, 97-Е, 98-Е, 99-Е, 100-Е,